

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Халтарын Бямбажав	Дугаар	L135
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Сүхбаатар
Төрсөн газар		Төрсөн он	1928
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Зүүн гуутын хийд, Арын нуурын хийд, Авдрантын хийд, Дэрсэн хашаатын хийд, Хайлаастын хүрээ, Ламын хийд, Пунгийн сүм	Сүм хийдийн дугаар	СБТЦ 060, СБСБ 045, СБСБ 046, СБСБ 044, СБСБ 043, СБСБ 048, СБСБ 047
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Зүүн гуутын хийд Сүхбаатар сумын Арын нуурын хийд, Авдрантын хийд, Дэрсэн хашаатын хийд, Хайлаастын хүрээ, Ламын хийд, Пунгийн сүм

-Нутаг орондоо байсан өөрийн мэдэх хуучны хийдүүдийн тухай ярьж өгөөч?

Дэрсэн хашаатын хийд гэж байсан. Тэр хойно Арын нуурын хийд гэж байсан. Сумын баруун хойно Ламын хийд гэж байсан.Энэ зүүн урд Пунгийн хийд гэж байсан. Энэ баруун урд Хавхаастын хийд гэж байсан. Тэнд бол тасаг (сүүний) байсан газар. Зүүн урд Авдарын хийд гэж байсан. Тэгээд Мандалын хийд гээд 8 хийд болж байгаа юм. Энэ бол сүм дуган цөөхөн.Баруунтай Мандалын хийд гэж бий. Вангай аймаг, Дангай аймаг, Шүтээн аймаг гээд 8 аймагтай, их том эртний хийд байж. Цогчэн дуганыг нь 1940-өөд оны үед аймаг байгуулагдах үед склад болгочихсон байсан. 10 хэдэн тэмээн тэрэг дотор нь ороод ачаагаа ачаад эргээд гараад ирдэг байсан гэж байгаа. Зис-5 машин ороод гарч байсан гэж байгаа.Тийм том хийд байсан юм. Гомбо сахиустай.Хэдэн гайгүй мэддэг улс маань үхээд өгсөн. Сүхбаатар сумын шинэ хийдийг би анх санаачлан бий болгосон хүн. Анхны ерөнхийлөгч байсан Очирбатад захиа бичиж байсан. Манай аймгийн дарга байсан Болд гэдэг хүн бол надад их тус болсон.Би сумын Ахмадын хорооны дарга байсан. Тэгээд хэдэн өвгөчүүл гуйдаг байсан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

юм. Амьд сэрүүн байхад минь орхимж тэнийлгээд өгөөч. Чамаас өөр дэмжээд хөөцөлдөөд өгөх хүн алга гээд өнөө хэд чинь гуйгаад байдаг. Та нар уншдаг лам нар хэд байгаа юм гэсэн. Хэдэн юм бий байхаа гээд. Тэгээд тэр жил яахав дээ. Манай энэ хойд уул байна. Энийг чинь Дарханхаан биш, Баянмөнххаан гэдэг юм. Энэ уулаа тахилаа. Хүүе тэгсэн өнөө гуйгаад байсан 3, 4 чинь биш, 15, 16 хүн суучихсан авч алдаж байна аа. За энэ чинь нээрээ уншаад байна уу, амаа хөдөлгөөд байна уу, яаж байна гээд чагнаад байсан чинь адилхан дуугараад байх юм. Тэгээд ийм улсууд байдаг юм байна гээд хоёр гэр гуйгаад уншлагын газар, Цогчэн дуган болгоод нээсэн. Нэгээр нь жас хийгээд тэгээд л эхэлж байлаа. 15, 16 ламтай хурлаа эхлээд тэр өвгөчүүл бол их мундаг улсууд байсан. Дандаа 84, 85-тай, нэрийн номтой тийм л хүмүүс байсан даа. Заан хайдав гэж улсын начин их эрдмийн хүн байсан. Тэрэн шиг нэрийн номтой хүн манай аймагт байхгүй. Тэгэхэд ганцхан тэр өвгөн л тангад номыг хараад л шууд монголоор уншдаг тийм хүн байсан. Тэгээд хүмүүс, чавганц нар чинь авдраа үүдлаад л 30 хэдэн тахил гаргаад надад өгч байсан. Лхогтой гүнрэг гээд судар өгч байсан. Хонх дамраа өгч байсан хүн байсан. Эд нар чинь юмаа хадгалаад байдаг байсан юм байна лээ. Ном их ирлээ. Тэгээд өвгөндөө л үзүүлнэ л дээ. Шууд орчуулаад л монголоор хэлнэ. Энэ чинь тэр уулын сан байна, энэ чинь тийм ном байна гээд л. Тэгээд тэрийг чинь монголоороо уншдаг хүн байсан шүү. Би дуганаа бариад ямаршуу янзтай байдаг бол одоо ямар болговол дээр юм зөвлөгөө авъя гэж бодоод Диваасамбуу ламыг аймагт ирсэн гэж дуулаад очиж авчирсан. Тэгээд заан өвгөн дээрээ оруулсан. Энэ өвгөнтэй жаахан ярьж гээд тэгээд тэр 2 нэг орой шөнөжингөө л ярьсан байх. Тэгээд маргааш нь гайхаж байсан. Ийм номтой, эрдэмтэй хүн бас байдаг юм байна аа гэж. Би хийдийн тухай бичсэн жаал зуугаа юмаа энэ Чулуунбаатарт өгсөн байгаа. Тэгээд амьд байхдаа бичээд үлдээчих юмсан гэсэн юм байгаа. Чаддаггүй ээ.

-Шинэ сэргээгдсэн хийдэд хурж байсан өвгөчүүл аль аль хийдэд сууж байсан хүмүүс вэ?

Дандаа энэ Хайлаастын хийдэд сууж байсан өвгөчүүл. Ганцхан энэ заан өвгөн л манай энэ хийдэд сууж байсан хүн байсан юм. Тэр бол амилсан эрдэмтэй хүн байсан юм. Та тэгээд яагаад гавж аграмба болоогүй юм бэ? танаас дор хүн болчихсон л байна шүү дээ гэдэг байсан.

Хайлаастын хийд 1750, 60-аад оны үүх түүхтэй юм шиг байдаг. Энэ хийдийн дуганыг 1950-аад оны үед нураасан. Буулгаж сургууль, ангийн склад зэргийг барьсан. Тэр моднууд бараг өмхрөөгүй шахуу байсан. Хаалган талынх нь мод бага зэрэг өмхөрсөн байсан. Тэгэхээр тэр дуганууд нь 1800-д, урагшлуулбал 1750, 60-аад оны үеийнх юм болов уу гэж дотроо боддог юм. Яг энэ тухай ярих ёстой хүмүүсээсээ асууж чадалгүй алдчихсан хүн би. Би уг бодож л байсан юм. Даанч чадалгүй алдчихсан юм.

-Та өөрийн санаж байгаа хөгшчүүлээс асууж, сонссон зүйлээ ярьж өгөхгүй юу?

Ер нь энэ хоёр хийдийн чинь лам нар их эрдэмтэй хүмүүс байсан гэнэ лээ. Энэ хойд хийд гэвэл эзний мэдээтэй хийд гэж яригддаг байсан.

-Ламын хийд үү?

Тийм ээ.

Хайдав гуай ярьдаг байсан л даа. Нэг их эрдэмтэй хүн байсан гэж байгаа юм аа. 33 боть ном хойно байгаа гэж. Тэр номыг нээж үзвэл гээд ярьж байсан. Би бас ажилд дарагдаад. Тухайн үедээ энэ шинэ хийдийг чинь нээж ажиллуулна гэдэг амаргүй ажилтай байлаа шүү дээ. Айлын гэрийг гуйж барина. Түлээг нь бэлтгэнэ. Бүх ширдэг дэвсгэрүүдийг бэлтгэнэ. Бурхан сахиусыг олж цуглуулна гээд бүтэн хоёр жил л явсан байгаа юм. Тэгээд яахав би ер нь дийлэхгүй нь гээд өөр нэг хүнд хүлээлгэж өгөөд гарсан даа. Тэгээд л жаахан юм асууж суръя гэсэн мэддэг хүн байхгүй болчихсон байсан даа. Одоо бол хийдүүдээс тэр тэнд сууж байсан гэх хүн байхгүй болсон. Бүгдээрээ байхгүй болсон.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Та хийдүүдийн төвд нэрийг хэлж өгнө үү?

Би мэдэхгүй. Манай суманд байгаа одооны энэ байгуулсан хийдийг Дашгүндэдлин гэдэг. Манай өвгөн өгч байсан юм. (заан өвгөн буюу Ламын хүрээнд сууж байсан Хайдав гуай) Эрдэнэ номун хийд гэж монголоор тэгж хэлж байсан юм.

-Энэ хийдүүд маань ер нь хэд орчим ламтай байсан бэ?

Ламын хүрээ, Хайлаастын хийд гээд?

Энэ тойрсон хийдүүд чинь дандаа цөөхөн цөөхөн ламтай байсан гэдэг юм аа. Гэхдээ тооны хувьд нэг 50, 60-аад байсан байх. Энэ зүүн урдах Пунгийн хийд нэлээн хэдэн ламтай байсан гэж ярьдаг юм байна лээ. 200-аад лам байсан юм болов уу, яасан юм бол. Дэрсэн хашаатын хийдэд 100-аад лам байсан байх. Авдарын хийд 100 гаруй 200-аад шахуу лам байсан байх. Бусад нь гэвэл дандаа цөөхөн. Энэ хойд Хайлаастын хийд нэг 200-д лам байсан юм шиг байгаа юм аа. Мандалын хийд харин нэлээн ламтай байсан гэж байгаа юм аа.

-Дугануудын хувьд, барилга байгууламж нь ямар байсан юм бэ?

Тэр Цогчэн дуган нь их том дуган байсан. Бусад нь жижиг байсан. Манай шинэ хийдийн дуган шиг л тиймэрхүү жижиг дуганууд байсан. Би Мандалын хийдийг мэдэж байна. Чойр дуган нь их том дуган байсан. 10 хэдэн тэмээн тэрэг ороод гардаг. Тийм том. Тэрний чинээ том дуган байхгүй ээ. Бид бол хэзээ хойно л үзэж байгаа юм шүү дээ. 1938 онд бага сургууль нээгдэж би орж байсан. Тэгэхэд тэр Мандалын хийдийн дуганд бөөн ном судар, бурхан тахил тараагаад хаячихсан байдаг байсан. Хөлөөр тарчихсан. Нэг их арцны үнэр. Бурханы шүншигний арц асгаад тэгж байсан юм байна лээ л дээ. Тийм байсан. Тэгээд тэр хүрээний чинь Сангай аймаг, Дангай аймаг хоёрын дуганд хоёр анги хичээллэдэг байсан. Сүүлд нь дотор нь пийшин барьж тэр үед ямар халаалт гэж байх биш, хаалган талдаа байрлуулаад, дээврээ цоолоод яндангаа гаргасан байсан. 20 хэд, 30-аад хүүхэд л байдаг байсан. Нэг дуганд эмнэлэг, нэгд мал эмнэлэг байсан. 1940-өөд оны эх гээд алга болоод өгсөн дөө. Хамгийн сүүлд Цогчэн дуган нураагдсан даа.

-Ламын хийдийн барилга байгууламжийн тухай?

Мэдэхгүй ээ. Намайг ирэхэд шавар л байсан. Бас л одоо нэлээн хэдэн дуган байсан л болтой юм байна лээ.

-Ийшээ Хулсан толгой гэдэгт дээр үеийн суурь түүрх байсан үү?

Би мэдэхгүй ээ. Энд тэнд байсан жижиг хийдийн тухай дуулаагүй ээ. Ер нь одоо дээхэн үед чинь жижиг хурлын газрууд байсан байгаа юм шиг байгаа юм.

-Пунгийн сүм өөр нэртэй байсан үү?

Тэрийг мэдэхгүй. Хамгийн том хийд л Мандалын хийд байсан. Цамтай, Майдартай. Тарган лам гэдэг байсан хүн овоо тойроод л Майдар эргэдэг байсан. Сор залж байсан. Би тэрийг нэг мүүхан мэддэг юм аа. 7,8 настай л байсан байх. Одоо ч үзсэн харсан хүн байтугай сонссон дуулсан хүн ховордоод байна. Би яахав хийд сэргээх ажилд гар бие оролцож хэдэн хөгшчүүлтэй ойр байсных жаахан юм дуулж сонирхож явсан. Би 1947 оны албан хаагч. Эвлэлийн үүрийн дарга, намын дарга хийж явсан. Намын дарга нар чинь тухайн үедээ лам нарыг үзэн ядагчид байсан байх. Гэхдээ би тэгж яваагүй юм шүү. Би ээжийнхээ сургаалаар дотроо боддог байсан. Тахилаа өргөж л байдаг, зулаа барьж л байдаг, гадаа хийморь хийсэж л байдаг би юм хэлдэггүй байсан. Төв хорооны нэг 30 гаран насны хүн ирээд хэд хэдэн хүмүүстэй уулзаад. Өнөө гэвш Санзай гуайтай уулзаад давхар хүн гэж ямар хүнийг хэлэх вэ? сүнс гэж байна уу энэ тэр гээд баахан юм асуугаад яваад байсан юм. Манайхны тэр Хөөдөө өвгөн чинь та ер нь давхар хүн гэж ямар хүнийг хэлдэг юм бэ? гэхээр би бодвол одоо жирэмсэн хүнийг л хэлдэг байх гэж, сүнс байна уу гэхдээр зэрэг би үхэж үзээгүй болохоор мэдэхгүй гэж хэлж байсан. Манай гэвш Санзай гуай бол шууд хэлж байна лээ. Байдаг юм аа хүү минь. Бүсээ чанга зангидаж тавьдаг юм. Дэрэн доороо хийдэг юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Сүнс гэж байна шүү дээ. Би байхгүй боллоо гэхэд энэний цаад талд бие махбодийг чинь бүтээж аваад явж байгаа юм сүнс байхгүй юу. Өөдөөс нь шууд хэлж байна лээ. Тэр хүн бол тийм үү гээд л байсан. Харин асууж байгаа нь танд одоо хүн амьтан ирж мөргөж шүтдэг үү, барьц энэ тэр өгдөг үү гэсэн, би юу? одоо тэр чинь байхгүй болсон штээ. Тэр чинь хамгийн цээртэй ажил байхгүй юу гэсэн. Санзай гуай ч одоо мундаг хүн байсан даа. Гэвш хүн байсан юм. Харин Жамъян гээд улсуудын хэн ч хэлчихсэн юм. Үлдтэй хүүхдийн толгойд шүлсээ түрхээд зүгээр болгосон гээд. Манай хүнийг бас л асуулаа. Их дүлий хүн байсан. Та ер нь сонин хуйлаад чихнийх нь нүхэнд хийхгүй бол наадах чинь дуулахгүй дээ гэсэн. Тэгээд би нэг сонин хуйлаад чихнийх нь нүхэнд хийгээд за одоо асуу гэлээ. Та хүний толгойд гарсан үлдийг эдгээдэг хүн гэсэн. Яаж эдгээдэг юм бэ? Та ер нь яадаг хүн юм гэсэн. Үгүй ээ би ийм тийм юм мэдэхгүй. Та чинь Намжил гэдэг хүний хүүхдийг тэгсэн байна шүү дээ гэсэн. Хэн мэдэхэв, хэн мэдэхэв. Настай улсууд урьд яр шарх гарахад шүлсээ түрхчихээд л байдаг. Би тэгсэн л байлгүй дээ гээд тэр дүлий хүнээс чинь яахав. Тэгээд Намжилаас асуусан. Тэр Жамъян гэдэг хүн танай хүүхдийн толгойд үлд гарсныг ном уншиж шүлсээ түрхээд эдгээсэн гэж байна. Энэ үнэн үү? гэхэд мэдэхгүй ээ, мэдэхгүй намайг гарах хооронд долоож л байсан гэж хэлээд тэгээд л гайгүй гарсан юм даа. Бас урьдны чадалтай улсууд ч байсан байгаа юм шүү. Миний сүүлийн мэдэхээр заан өвгөн шиг эрдэмтэй чадалтай хүн байгаагүй.